

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/286/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН БАЯНБУЛАГ ЦЭЦЭРЛЭГИЙН
ТӨСВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл.....
 - 4.2 Материаллаг байдал.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 0/157
танай _____ -ны № _____ -г

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН БАЯНБУЛАГ ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БАТЧИМЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 8 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж 98,0 хувиар хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,907,849.32	106,494,641.37
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	57,660,992.05
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	57,660,992.05
3121	Төгрөг	-	57,660,992.05
31211	Төрийн сангийн харилцах	-	57,660,992.05
35	БАРАА МАТЕРИАЛ	44,907,849.32	48,833,649.32
354	Хангамжийн материал	44,907,849.32	48,833,649.32
35410	Бичиг хэргийн материал	-	396,000.00
35440	Түлш шатах тослох материал	2,035,200.00	3,121,600.00
35460	Хүнсний материал	72,600.00	-
35470	Бусад хангамжийн материал	42,800,049.32	45,316,049.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	141,413,906.11	129,321,900.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	141,413,906.11	129,321,900.71
392	Биет хөрөнгө	137,211,906.11	125,119,900.71
39201	Барилга, байгууламж	177,550,845.01	177,550,845.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(44,423,047.20)	(55,528,809.00)
39205	Машин, тоног төхөөрөмж	28,588,996.00	25,455,308.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,200,507.18)	(24,460,174.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,307,111.40	15,507,111.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,198,381.92)	(14,881,270.03)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,301,200.00	20,301,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,191,200.00)	(20,301,200.00)
39217	Номын фонд	1,476,890.00	1,476,890.00
393	Биет бус хөрөнгө	4,202,000.00	4,202,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,202,000.00	4,202,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	186,321,755.43	235,816,542.08
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	186,321,755.43	235,816,542.08
51	Засгийн газрын хувь оролцоо	186,321,755.43	235,816,542.08
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	52,847,094.26	52,847,094.26
51101	Өмч: -Төрийн өмч	52,847,094.26	52,847,094.26
512	Хуримтлагдсан үр дүн	83,126,582.05	132,682,717.30
51210	Өмнөх үеийн үр дүн	83,126,582.05	83,187,930.65
51220	Тайлант үеийн үр дүн	-	49,494,786.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	50,348,079.12	50,286,730.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	186,321,755.43	235,816,542.08

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	387,024,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	364,244,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	2,472,000.00
12000	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	2,472,000.00
12000	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,472,000.00
122	Тусламжийн орлого	-	361,772,500.00
12200	Хандив тусламж /дотоод/	-	361,772,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	22,780,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	22,780,000.00
13200	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	22,780,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	-	337,529,713.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	337,529,713.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	334,623,253.45
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	220,643,224.96
21010	Цалин	-	164,423,527.66
21010	Нэмэгдэл цалин	-	48,950,371.80
21010	Урамшуулал	-	7,269,325.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	27,771,182.99
21020	Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	19,130,492.23
21020	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	2,319,870.64
21020	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	1,761,496.58
21020	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	407,988.87
21020	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	4,151,334.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	20,431,740.10
21030	Гэрэл цахилгааны зардал	-	6,308,540.10
21030	Түлш, халаалтын зардал	-	13,947,200.00
21030	Цэвэр, божир усны зардал	-	176,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,623,400.00
21040	Бичиг хэргийн материал	-	176,200.00
21040	Тээвэр, шатахууны зардал	-	2,929,700.00
21040	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	-	1,517,500.00
2105	Нормативт зардал	-	41,965,250.00
21050	Эм	-	82,500.00
21050	Хоол	-	41,882,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	1,502,250.00
21080	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,277,250.00
21080	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	-	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,686,205.40
21090	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,000,000.00
21090	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	1,382,200.00
21090	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	13,304,005.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,906,459.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,140,600.00
21320	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,140,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох т	-	765,859.90
21340	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	765,859.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	-	49,494,786.65
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	-	49,494,786.65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	384,552,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	361,772,500.00
122	Тусламжийн орлого	-	361,772,500.00
122005	Хандив тусламж /дотоод/	-	361,772,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	22,780,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	22,780,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	22,780,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	-	326,125,648.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	326,125,648.05
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	323,985,048.05
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	-	220,642,684.96
210101	Үндсэн цалин	-	164,422,987.66
210102	Нэмэгдэл	-	48,950,371.80
210104	Үр дүнгийн урамшуулал	-	7,269,325.50
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	-	27,771,722.99
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	-	19,130,492.23
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	-	2,319,870.64
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	-	1,761,496.58
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	-	407,988.87
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	-	4,151,874.67
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	-	21,518,140.10
210301	Гэрэл цахилгааны зардал	-	6,308,540.10
210302	Түлш, халаалтын зардал	-	13,428,000.00
210303	Цэвэр, бохир усны зардал	-	1,781,600.00
2105	Нормативт зардал	-	41,810,150.00
210502	Хоол, хүнс	-	41,810,150.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	496,000.00
210604	Урсгал засвар	-	496,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	225,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,521,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,545,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	-	1,976,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,140,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,140,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,140,600.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	58,426,851.95
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	58,426,851.95
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	57,660,992.05

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	ДАНС	511.00	51,300.00	51210+51220	
C01	2022 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	-	-	-	-
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,847,094	50,348,079	83,126,582	186,321,755
D01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,847,094	50,348,079	83,126,582	186,321,755
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	61,349	61,349
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,847,094	50,348,079	83,187,931	186,383,104
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(61,349)	-	(61,349)
D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	49,494,787	49,494,787
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52,847,094	50,286,731	132,682,717	235,816,542

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлтийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,552,700.00	326,125,648.05	58,427,051.95	84.81
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	384,552,700.00	326,125,648.05	58,427,051.95	84.81
210	Бараа, үйлчилгээний зардал	382,412,100.00	323,985,048.05	58,427,051.95	84.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,563,900.00	220,642,684.96	47,921,215.04	82.16
210101	Үндсэн цалин	180,568,000.00	164,422,987.66	16,145,012.34	91.06
210102	Нэмэгдэл	78,577,500.00	48,950,371.80	29,627,128.20	62.30
210104	Урамшуулал	9,418,400.00	7,269,325.50	2,149,074.50	77.18
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,570,700.00	27,771,722.99	5,798,977.01	82.73
210201	Тэтгэврийн даатгал	22,827,900.00	19,130,492.23	3,697,407.77	83.80
210202	Тэтгэмжийн даатгал	2,685,500.00	2,319,870.64	365,629.36	86.39
210203	ҮОМШӨ ний даатгал	2,148,600.00	1,761,496.58	387,103.42	81.98
210204	Ажилгүйдлийн даатгал	537,300.00	407,988.87	129,311.13	75.93
210205	Эрүүл мэндийн даатгал	5,371,400.00	4,151,874.67	1,219,525.33	77.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,280,000.00	21,518,140.10	761,859.90	96.58
210301	Гэрэл цахилгаан	7,813,400.00	6,308,540.10	1,504,859.90	80.74
210302	Түлш, халаалт	12,003,200.00	13,428,000.00	(1,424,800.00)	111.87
210303	Цэвэр, бохир ус	2,463,400.00	1,781,600.00	681,800.00	72.32
2105	Нормативт зардал	44,208,600.00	41,810,150.00	2,398,450.00	94.57
210502	Хоол, хүнс	44,208,600.00	41,810,150.00	2,398,450.00	94.57
2106	Эд хогшил худалдан авах	500,000.00	496,000.00	4,000.00	99.20
210604	Урсгал засвар	500,000.00	496,000.00	4,000.00	99.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	658,700.00	225,000.00	433,700.00	34.16
210806	Мэдээллийн технологийн зардал	658,700.00	225,000.00	433,700.00	34.16
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	12,630,200.00	11,521,350.00	1,108,850.00	91.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,654,200.00	9,545,350.00	1,108,850.00	89.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,976,000.00	1,976,000.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,140,600.00	2,140,600.00	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,140,600.00	2,140,600.00	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,140,600.00	2,140,600.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,552,500.00	384,552,500.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	361,772,500.00	361,772,500.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	361,772,500.00	361,772,500.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	22,780,000.00	22,780,000.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	22,780,000.00	22,780,000.00	-	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	57,660,992.05	(57,660,992.05)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	14.00	14.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг бие бялдар оюун ухаан нийгэмшихүй хөгжлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь 2023 оныг "Залуучуудын хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 8 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 98,0 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус цэцэрлэг нь 14 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

2023 оны 11 сард аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдсан 95,7 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 49,494.8 сая төгрөгөөр буюу 26,6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	57,660.9	57,660.9
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	44,907.8	48,833.7	3,925.9
Үндсэн хөрөнгө	141,413.9	129,321.9	-12,092.0
Нийт хөрөнгө	186,321.7	235,816.5	49,494.8
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	186,321.7	235,816.5	49,494.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	186,321.7	235,816.5	49,494.8

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 57,660.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн зарцуулалтыг хэмнэснээс шалтгаалжээ. Үүнд: цалин хөлс нэмэгдэл түүнтэй холбогдох зардлыг 53,720.2 мянган төгрөгөөр, бусад тогтмол зардлыг 3,940.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 48,833.7 мянган төгрөг болж 3,925.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 66,657.8 мянган төгрөгөөр эм боох материал, бичиг хэрэг, аж ахуй материал, түлш шатах тослох материал, хүнсний материал, барилгын засварын материал, хандиваар 1,260.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал тус тус худалдан авсан. Тайлант онд цэцэрлэг нь өөрийн үйл ажиллагаанд 63,992.0 мянган төгрөгийн эм боох материал, бичиг хэрэг, аж ахуйн бараа материал, шатах тослох материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд Боловсрол шинжлэх ухааны яамнаас Хандиваар 1,012.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга авсан.

Тайлант онд Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 06-ны А/02 тоот тогтоолоор 4,145.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж данснаас хассан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 361,772.5 мянган төгрөг, орон нутгаас 22,780.0 мянган төгрөг, нийт зарлагыг 326,125.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 384,552.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 384,552.7 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 326,125.6 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 226,125.6 мянган төгрөг буюу 84,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 326,125.6 мянган төгрөгөөр, хэмнэсэн, үүнээс цалин хөлстэй холбоотой зардлын төсвийг 47,921.2 мянган төгрөгөөр, байр ашиглах зардал, хоол хүнсний зардлыг 3,160.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Орон нутгийн төсвөөс 22,780.0 мянган төгрөгөөр тогтмол зардлыг санхүүжүүлсэн.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	71801-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605- Эрүүл мэндийг дэмжих	988.0	790.0	488.1	64.8%
2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	43,515.6	41,117.1	4,355.2	90.8%
3	81823- Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	988.0	480.0	61.6	94.9%
4	81832- Нүүдлийн бүлэгт хамруулах	2,223.0	941.0	1,672.4	72.3%
5	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	22,280.0	22,280.0	-	41.5%
6	81834- Боловсролын стандарт	227,570.5	192,475.9	26,047.9	90.2%
7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	84,308.2	66,128.1	11,385.5	78.8%
8	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,179.4	2,179.4	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71801-81605	2023-12-31	Эрүүл мэндийг дэмжих	64.8%	988.0	790.0
2	71801-81807	2023-12-31	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	90.8%	43,515.6	41,117.1
3	71801-81823	2023-12-31	Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	94.9%	988.0	480.0
4	71801-81832	2023-12-31	Нүүдлийн бүлэгт хамруулах	72.3%	2,223.0	941.0
5	71801-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	41.5%	22,280.0	22,280.0
6	71801-81834	2023-12-31	Боловсролын стандарт	90.2%	227,570.5	192,475.9
7	71801-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	78.8%	84,308.2	66,128.1
8	71801-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100%	2,179.4	2,179.4

Цэцэрлэгийн хүүхдийн хоол арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь сургуулийн хүүхдийн улирлын амралттай холбоотойгоор хүүхдийн ирц багасдагтай холбоотойгоор хэмнэгдсэн. Нүүдлийн бүлэгт хамруулах арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь орон тоо хэмнэсэн, хүүхдийн ирцтэй холбоотойгоор хэмнэгдсэн.

Сургалтын хэвийн үйл ажиллагаа арга хэмжээ нь дутуу хэрэгжсэн нь томуу, томуу төст өвчин ихэссэн, СӨБ цахимд шилжсэнтэй холбоотойгоор хүүхдийн ирц буурч хэмнэгдсэн.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын худалдан авах ажиллагаанаас тендер зарласан боловч нэгч аж ахуй нэгж байгууллага тендерт оролцоогүй тул шууд худалдан авалт хийсэн. Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Сумын албан бичгээр Арвинбат ХХК-аас 41,810.1 мянган төгрөгийн хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний материалыг шууд худалдан авалтаар авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 600,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 12,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9,600,0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорх хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 47,921.2 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 761.8 мянган төгрөгөөр
- Нормативт зардлыг 2,398.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэг нь 2023 онд шилэн дансанд 159 мэдээлэл оруулахаас 153 мэдээллийг хугацаанд нь мэдээлж 6 мэдээлэл хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулж, зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн ба өмнөх аудитаар өгсөн алдаа зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Жаргалант сумын Баянбулаг цэцэрлэгийн 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн завсрын аудитын явцад зардлын данстай холбоотой 2,045.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2023 онд шинээр байгуулагдсан байгууллага.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж					
Нийт дүн	-	-	-	-	-

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,918.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,918.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны жишиг орц нормыг дагаж мөрдөөгүйн улмаас 1,918.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02 өдрийн А\166, А\556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын /4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

Дээрх Албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүхдийн хоногийн хоолны хэрэгцээг хангах бүтээгдэхүүн хүнсний жишиг хэмжээг орц нормын дагуу бодогдоогүй	1	1.918.3			1	1.918.3						
Дүн	1	1.918.3			1	1.918.3						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
							Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээлэл 159 оруулахаас 153 оруулж, 6 мэдээлэл	1							1	

хугацаа хоцроосон								
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn